



**БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ**

2014 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Барилгын норм ба дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, “Барилгын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтууд, мөн Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 04 дүгээр хуралдааны тэмдэглэл зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Барилгын зураг төсөл боловсруулах барилгын норм ба дүрэм “Зуухны тоног төхөөрөмж”/БНБД 41-03-13/-ыг 1 дүгээр хавсралтаар; “Дулааны сүлжээ”/БНБД 41-02-13/-ийг 2 дугаар хавсралтаар; “Тоног төхөөрөмж, дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт”/БНБД41-04-13/ -ийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2005 оны 101 дүгээр тушаал “Гадна дулаан хангамж” /БНБД 41-02-05/; мөн 2007 оны 160 дугаар тушаал “Зуухны тоног төхөөрөмж”/БНБД41-03-07/-ийг; 1999 оны 82 дугаар тушаал “Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт” /БНБД 41-03-99/-ийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Шинээр батлагдсан барилгын норматив баримт бичгийг хэвлэн олшруулж, зураг төсөл болон барилга угсралтын байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлэн сурталчлан ажиллахыг Барилгын хөгжлийн төв /Б.Баярсайхан/-д “Барилгын эрчим хүчний хэмнэлтийн төсөл МОН/09/301” /Б.Мөнхбаяр/-д нарт даалгасугай.

Дөрөв. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Цэдэнсамба/-д үүрэг болгосугай.




Ц.БАЯРСАЙХАН

113

БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

Барилга, хот байгуулалтын сайдын 2014 оны
08 дугаар сарын 26-ны өдрийн 136 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ЗУУХНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

БНБД 41-03-13

Албан ёсны хэвлэл

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Улаанбаатар хот
2013 он